

# ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:  
Утас: 70378845  
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  
Аудитын менежер: У.Батсүрэн  
Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Батцэцэг  
Утас: 70373089  
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК  
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг  
Утас: 88883776  
Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
5.1 Төлбөрийн акт.....	9
5.2 Албан шаардлага.....	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 60

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАРХАН СУМЫН 12 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
В.ОТГОНХҮҮ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн

4529050159

хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар цэцэрлэг нь 2025 онд 4 зорилт 44 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>368,322,275.55</u></b>	<b><u>137,955,409.62</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	276,588,664.78	47,318,780.19
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	276,588,664.78	47,318,780.19
31211	Төрийн сангийн харилцах	276,588,664.78	47,318,780.19
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>91,733,610.77</u></b>	<b><u>90,636,629.43</u></b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,456,057.00	1,338,621.00
35110	Тусгай зориулалттай материал	1,456,057.00	1,338,621.00
35130	Эм боох материал	1,456,057.00	1,338,621.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	90,277,553.77	89,298,008.43
35410	Бичиг хэргийн материал	4,699,450.00	4,883,800.00
35420	Аж ахуйн материал	48,555,483.40	33,386,325.00
35460	Хүнсний материал	2,583,554.30	2,339,359.00
35470	Бусад хангамжийн материал	34,439,066.07	48,688,524.43
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,561,675,409.30</u></b>	<b><u>1,467,480,383.21</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,561,675,409.30	1,467,480,383.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,220,115,409.34	1,126,550,383.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,340,476,855.20	1,340,476,855.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(284,363,989.11)	(355,952,091.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,623,150.00	130,544,618.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,587,391.91)	(59,953,191.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,782,882.00	23,750,711.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,581,825.07)	(10,134,534.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	110,110,247.66	110,668,007.66
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,332,319.43)	(52,849,991.53)
39217	Ном	987,800.00	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	341,559,999.96	340,929,999.96
39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(590,000.04)	(1,220,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	340,300,000.00	340,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,929,997,684.85</u></b>	<b><u>1,605,435,792.83</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,268,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	10,268,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	10,268,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,929,997,684.85</u></b>	<b><u>1,605,435,792.83</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,929,997,684.85	1,605,435,792.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	656,825,028.50	656,825,028.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(138,411,998.11)	(462,973,890.13)
51210	Өмнөх үеийн үр дүн	(138,411,998.11)	(138,411,998.11)
51220	Тайлант үеийн үр дүн		(324,561,892.02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,411,584,654.46	1,411,584,654.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,929,997,684.85</u></b>	<b><u>1,605,435,792.83</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,404,189,500.00</b>	<b>1,248,788,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,404,189,500.00</b>	<b>1,248,788,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,342,863,600.00	1,176,592,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,342,863,601.00	1,176,592,701.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		70,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	1,076,680.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	61,325,900.00	72,126,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,325,900.00	72,126,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,318,261,604.75</b>	<b>1,633,540,879.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,318,261,604.75</b>	<b>1,633,540,879.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,302,913,609.94	1,630,863,836.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	883,059,291.26	1,068,798,196.91
210101	Үндсэн цалин	609,693,592.34	709,414,073.10
210102	Нэмэгдэл	238,491,018.92	286,520,104.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	40,019,570.16
210104	Урамшуулал	34,874,680.00	32,844,449.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	111,280,224.13	133,274,067.68
210201	Тэтгэврийн даатгал	76,294,050.67	90,420,334.08
210202	Тэтгэмжийн даатгал	9,006,248.80	10,713,358.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,408,112.59	5,356,779.60
210204	Ажилгүйдлийн даатгал	4,284,598.59	5,356,779.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,287,213.48	21,426,817.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,311,105.19	55,939,299.56
210301	Гэрэл, цахилгаан	9,230,177.21	12,183,471.84
210302	Түлш, халаалт	16,334,731.72	17,780,526.72
210303	Цэвэр, бохир ус	13,746,196.26	25,975,301.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,384,700.00	19,709,042.64
210401	Бичиг хэрэг	389,600.00	6,036,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,995,100.00	2,197,700.00
210408	Бараа материал акталсны зардал		11,474,492.64
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	151,919,513.40	160,546,771.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	554,270.70	780,086.00
210502	Хоол, хүнс	151,365,242.70	159,766,685.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,895,000.00	30,119,530.00
210604	Урсгал засвар	9,895,000.00	30,119,530.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,465,700.00	1,774,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,465,700.00	1,774,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	102,598,075.96	160,702,428.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,901,400.00	16,041,807.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,553,600.00	1,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,143,075.96	143,460,620.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,347,994.81	2,677,042.83
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,833,200.00	-

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,879,956.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,833,200.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,514,794.81	2,677,042.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,514,794.81	2,677,042.83
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>142,463,465.25</b>	<b>(321,578,218.74)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	490,200.00	2,983,673.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		987,800.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	490,200.00	1,995,873.28
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(490,200.00)	(2,983,673.28)
<b>5</b>	<b>НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>141,973,265.25</b>	<b>(324,561,892.02)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,404,189,500.00</b>	<b>1,248,788,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,404,189,500.00</b>	<b>1,248,788,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,342,863,600.00	1,176,592,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,342,863,600.00	1,176,592,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		70,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	61,325,900.00	72,126,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,325,900.00	72,126,000.00
<b>2</b>	<b>НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,261,185,903.59</b>	<b>1,475,501,541.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,261,185,903.59</b>	<b>1,475,501,541.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,245,837,908.78</b>	<b>1,475,501,541.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	883,059,291.26	1,068,798,197.51
210101	Үндсэн цалин	609,693,592.34	709,414,073.70
210102	Нэмэгдэл	238,491,018.92	286,520,104.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	40,019,570.16
210104	Урамшуулал	34,874,680.00	32,844,449.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	111,280,224.13	133,274,067.08
210201	Тэтгэврийн даатгал	76,294,050.67	90,420,334.08
210202	Тэтгэмжийн даатгал	9,006,248.80	10,713,358.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,408,112.59	5,356,779.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,284,598.59	5,356,779.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,287,213.48	21,426,817.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,311,105.19	56,452,257.17
210301	Гэрэл, цахилгаан	9,230,177.21	12,696,429.45
210302	Түлш, халаалт	16,334,731.72	17,780,526.72
210303	Цэвэр, бохир ус	13,746,196.26	25,975,301.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	150,478,001.00	159,522,490.00
210502	Хоол, хүнс	150,478,001.00	159,522,490.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,500,000.00	7,996,700.00
210604	Урсгал засвар	19,500,000.00	7,996,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,190,600.00	1,999,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,190,600.00	1,999,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,018,687.20	42,458,430.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,870,687.20	30,129,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,148,000.00	12,329,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,347,994.81	2,677,042.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,833,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,833,200.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,514,794.81	2,677,042.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,514,794.81	2,677,042.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>143,003,596.41</u>	<u>(224,389,884.59)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,565,200.00	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,565,200.00	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,565,200.00	5,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,361,000.00	1,854,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,565,200.00)</u>	<u>(5,000,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	136,438,396.41	(229,389,884.59)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	140,150,268.37	276,588,664.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	276,588,664.78	47,318,780.19

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	3,561,267.14	2,104,970,950.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	3,561,267.14	2,104,970,950.10
Тайлант үеийн үр дүн	-	-	(141,973,265.25)	(141,973,265.25)
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	(138,411,998.11)	1,929,997,684.85
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	(138,411,998.11)	1,929,997,684.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	(138,411,998.11)	1,929,997,684.85
Тайлант үеийн үр дүн	-	-	(324,561,892.02)	(324,561,892.02)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	656,825,028.50	1,411,584,654.46	(462,973,890.13)	1,605,435,792.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		276,588,664.78	(276,588,664.78)
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,160,133,400.00</b>	<b>1,405,932,584.59</b>	<b>(245,799,184.59)</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,160,133,400.00</b>	<b>1,405,932,584.59</b>	<b>(245,799,184.59)</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,160,133,400.00</b>	<b>1,405,932,584.59</b>	<b>(245,799,184.59)</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>847,716,400.00</b>	<b>1,068,798,197.51</b>	<b>(221,081,797.51)</b>
210101	Үндсэн цалин	588,415,100.00	709,414,073.70	(120,998,973.70)
210102	Нэмэгдэл	228,784,700.00	286,520,104.12	(57,735,404.12)
	Унаа хоолны хөнгөлөлт		40,019,570.16	(40,019,570.16)
210104	Урамшуулал	30,516,600.00	32,844,449.53	(2,327,849.53)
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,964,600.00</b>	<b>133,274,087.08</b>	<b>(27,309,487.08)</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,055,900.00	90,420,334.08	(18,364,434.08)
210202	Тэтгэмжийн даатгал	8,477,100.00	10,713,358.00	(2,236,258.00)
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,238,600.00	5,356,779.00	(1,118,179.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	4,238,600.00	5,356,799.00	(1,118,199.00)
210205	Эрүүл мэндийн даатгал	16,954,400.00	21,426,817.00	(4,472,417.00)
2105	<b>Нормативт зардал</b>	<b>171,761,600.00</b>	<b>159,522,490.00</b>	<b>12,239,110.00</b>
210502	Хоол хүнс	171,761,600.00	159,522,490.00	12,239,110.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,626,700.00</b>	<b>1,999,400.00</b>	<b>2,627,300.00</b>
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	4,626,700.00	1,999,400.00	2,627,300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,064,100.00</b>	<b>42,458,430.00</b>	<b>(12,394,330.00)</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,242,000.00	30,129,430.00	(7,887,430.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,822,100.00	12,329,000.00	(4,506,900.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,097,516,000.00</b>	<b>1,176,662,700.00</b>	<b>(79,146,700.00)</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,097,516,000.00</b>	<b>1,176,592,700.00</b>	<b>(79,076,700.00)</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,097,516,000.00	1,176,592,700.00	(79,076,700.00)
	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>276,588,664.78</b>	<b>70,000.00</b>	<b>276,518,664.78</b>
	Төсөв байгууллагын өөрийн орлого		70,000.00	(70,000.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	276,588,664.78	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	47,318,780.19	

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>79,121,300.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,342.83</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>79,121,300.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,342.83</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>79,121,300.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,342.83</b>
2103	<b>БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ</b>	<b>66,121,300.00</b>	<b>56,452,257.17</b>	<b>9,669,042.83</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,372,000.00	12,696,429.45	<b>2,675,570.55</b>
21302	Түлш халаалт	26,318,900.00	17,780,526.72	<b>8,538,373.28</b>
21303	Цэвэр, бохир ус	24,430,400.00	25,975,301.00	<b>(1,544,901.00)</b>
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>79,121,300.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,342.83</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>79,121,300.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,342.83</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	<b>79,121,302.00</b>	<b>69,448,957.17</b>	<b>9,672,344.83</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,456.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэн тул 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

1. Тус цэцэрлэгийн эрхлэгч В.Отгонхүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлснөөс тооцоогүйгээс нийт 356,400.00 төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 56.2-т "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Тайлант онд тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч В.Отгонхүүгийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дэлгэрэнгүй заавар"-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

## 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч В.Отгонхүү нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,500,400.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган  
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлснөөс тооцоогүйгээс нийт 356,400.00 төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	356.4	1	356.4	-	-	-	-	-	-	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч В.Отгонхүүгийн сургалтын төлбөрт	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	

600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан											
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,500,400.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй	1	2,500.4	-	-	1	2,500.4	-	-	-	-	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,456.88</b>	<b>2</b>	<b>956.4</b>	<b>1</b>	<b>2,500.4</b>			-	-	-